



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 38

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 6 нэрийн, нийт 270,720,000.00 (хоёр зуун далан сая долоон зуун хорин мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 18,720,000.00 (арван найман сая долоон зуун хорин мянга) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн дарга Б.Эрдэнэваанчигт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ



132000208
2-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 01 дугаар сарын 08-ны өдрийн
38 дугаар тогтоолын хавсралт

СПОРТЫН АНАГААХ УХААН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТЭЛТЭЙ,
АШИГЛАХ ХУГАЦААГ СУНГАЖ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж балансын үнэ	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл	Шинэчлэн тогтоох нэг бүрийн үнэ	Шинэчлэн тогтоосон нийт үнэ	Цаашид ашиглах хугацаа /жил/
Машин, тоног төхөөрөмж									
1	Цахилгаан эмчилгээний аппарат /GP 102D TENS/	1/4/2021	ширхэг	1	1,320,000	1,320,000.00	264,000.00	264,000.00	2
	Машин, тоног төхөөрөмжийн дүн			1		1,320,000.00	264,000.00	264,000.00	
Программ хангамж									
2	Сэтгэл зүйн тест /Эргоскоп АВР4 /	10/1/2019	ширхэг	1	48,000,000	48,000,000.00	9,600,000.00	9,600,000.00	2
	Программ хангамжийн дүн			1		48,000,000.00	9,600,000.00	9,600,000.00	
Бусад үндсэн хөрөнгө									
3	Биеийн баланс тодорхойлох багаж / Optogait 5m /	2019.10.01	ширхэг	1	85,000,000	85,000,000.00	3,400,000.00	3,400,000.00	2
4	Дээд үе мөчний Ergomedic 891E Монарк - 891E / ком /	2019.10.01	ширхэг	1	22,900,000	22,900,000.00	916,000.00	916,000.00	2
5	Доод үе мөчний Ergomedic 894E / Монарк 894E /	2019.10.01	ширхэг	1	19,500,000	19,500,000.00	780,000.00	780,000.00	2
6	Хүний биеийн гадаргуу бүтэц тодорхойлох ABW Mapper ком /	2019.10.01	ширхэг	1	94,000,000	94,000,000.00	3,760,000.00	3,760,000.00	2
	Бусад үндсэн хөрөнгийн дүн			4		221,400,000.00	8,856,000.00	8,856,000.00	
	Нийт дүн			6		270,720,000.00 (хоёр зуун далан сая долоон зуун хорин мянга)		18,720,000.00 (арван найман сая долоон зуун хорин мянга)	